



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/129/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын,
дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigul@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат
Утас: 70007275 Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТБОНӨБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМҮЗ	Эрүүл мэндийн үндэсний зөвлөл



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

НОГООННУУР СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
К. АУКЕТАЙ ТАНАА

2025.02.25 № 227
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй байна.

Аудитын гол асуудал

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,703.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, 1,635.4 сая төгрөг зарцуулж, 96.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилго, 4 зорилтын хүрээнд нийт 42 арга хэмжээ 76 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>265,143,812.53</u>	<u>340,511,980.86</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	64,547,336.37	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	64,547,336.37	-
3121	Төгрөг	64,547,336.37	-
31211	Төрийн сангийн харилцах	64,547,336.37	-
33	АВЛАГА	24,802,434.00	145,920,470.17
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	24,802,434.00	145,920,470.17
35	БАРАА МАТЕРИАЛ	175,794,042.16	194,591,510.69
351	Түүхий эд материал	116,594,785.16	133,647,289.29
35130	Эм боох материал	116,594,785.16	133,647,289.29
354	Хангамжийн материал	59,199,257.00	60,944,221.40
35410	Бичиг хэргийн материал	2,301,410.00	2,499,750.00
35440	Түлш, шатах тослох материал	2,584,772.00	376,305.00
35460	Хүнсний материал	6,437,522.00	8,181,712.00
35470	Бусад хангамжийн материал	47,875,553.00	49,886,454.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,541,868,576.37</u>	<u>2,366,569,292.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,541,868,576.37	2,366,569,292.15
392	Биет хөрөнгө	1,507,115,176.34	2,332,035,892.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,424,907,312.00	2,250,894,736.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(162,751,438.60)	(204,256,409.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	192,276,429.00	288,634,761.90
39204	Хуримтлагдсан элэгдэл	(108,860,178.78)	(145,311,613.98)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	314,632,682.73	357,084,912.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(190,372,874.89)	(243,344,391.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,955,512.00	83,230,512.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,848,767.14)	(55,023,115.54)
39214	Бусад үндсэн хөрөнгө	340,000.00	340,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(289,999.98)	(340,000.00)
39217	Ном	126,500.00	126,500.00
393	Биет бус хөрөнгө	34,753,400.03	34,533,400.07
39301	Програм хангамж	1,430,000.00	1,430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(714,999.97)	(934,999.93)
39303	Бусад биет бус хөрөнгө	34,038,400.00	34,038,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,807,012,388.90</u>	<u>2,707,081,273.01</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,807,012,388.90</u>	<u>2,707,081,273.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,807,012,388.90	2,707,081,273.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	704,890,598.00	704,890,598.00
51101	Өмч:- төрийн	704,890,598.00	704,890,598.00
512	Хуримтлагдсан үр дүн	369,268,868.42	1,269,337,752.53
51210	Өмнөх үеийн үр дүн	369,268,868.42	369,268,868.42
51220	Тайлант үеийн үр дүн	-	900,068,884.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	732,852,922.48	732,852,922.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,807,012,388.90</u>	<u>2,707,081,273.01</u>

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,489,732,838.65	2,661,302,105.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	418,081,631.28	1,037,053,682.47
120	Нийтлэг татварын бус орлого	418,081,631.28	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	418,081,631.28	1,037,053,682.47
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	67,758,545.47
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	418,081,631.28	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	73,949,239.00	956,872,987.10
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,500,000.00	12,422,149.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,071,651,207.37	1,624,248,422.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,104,700.00	28,824,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,104,700.00	28,824,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,044,546,507.37	1,595,423,722.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,044,546,507.37	1,595,423,722.80
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,242,737,828.73	1,761,233,221.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,242,737,828.73	1,761,233,221.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,242,737,828.73	1,761,233,221.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	751,786,406.00	1,138,549,276.63
210101	Үндсэн цалин	536,222,904.00	684,570,669.63
210102	Нэмэгдэл	148,264,402.00	357,201,607.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,462,000.00	23,003,000.00
210104	Урамшуулал	56,837,100.00	73,774,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,042,197.00	145,302,273.55
210201	Тэтгэврийн даатгал	94,042,197.00	97,346,373.55
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	11,988,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	5,994,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	5,994,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	23,978,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,405,281.00	27,426,867.00
210301	Гэрэл, цахилгаан	4,164,628.00	4,684,900.00
210302	Түлш, халаалт	20,240,653.00	22,741,967.00
2104	Хангамж, бараа материалын зардал	106,237,063.00	99,819,506.00
210401	Бичиг хэрэг	3,000,900.00	1,637,660.00
210402	Тээвэр, шатахуун	76,998,270.00	76,406,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,593,780.00	3,101,690.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	898,500.00	625,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,987,380.00	16,127,418.00
210408	Бараа материал акталсны зардал	9,758,233.00	1,920,838.00
2105	Нормативт зардал	125,691,563.71	126,393,780.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79,884,440.71	94,124,570.19
210502	Хоол, хүнс	45,807,123.00	31,969,210.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	899,000.00	5,132,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	94,000.00	00.00
210604	Урсгал засвар	805,000.00	5,132,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,520,000.00	3,164,000.00
210702	Дотоод албан томилолт	2,520,000.00	3,164,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	1,326,226.00	1,980,701.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	төлбөр, хураамж		
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	439,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,000.00	161,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	810,500.00	1,081,000.00
210807	Газрын төлбөр	299,276.00	299,276.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,830,092.02	213,464,116.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,818,700.00	73,091,845.47
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,011,392.02	140,372,271.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>246,995,009.92</u>	<u>900,068,884.11</u>

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,046,848,773.37	1,570,888,932.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	67,758,545.47
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	67,758,545.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	67,758,545.47
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	67,758,545.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,046,848,773.37	1,503,130,386.63
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,104,700.00	28,824,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,104,700.00	28,824,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,019,744,073.37	1,474,305,686.63
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,019,744,073.37	1,474,305,686.63
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,113,860,068.00	1,627,236,268.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,113,860,068.00	1,627,236,268.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,113,860,068.00	1,627,236,268.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	751,897,803.00	1,137,325,276.63
210101	Үндсэн цалин	513,303,791.00	683,346,669.63
210102	Нэмэгдэл	166,942,895.00	357,201,607.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,795,000.00	23,003,000.00
210104	Урамшуулал	60,856,117.00	73,774,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,930,800.00	145,302,273.55
210201	Тэтгэврийн даатгал	63,706,100.00	97,346,373.55
210202	Тэтгэмжийн даатгал	7,557,300.00	11,988,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,037,800.00	5,994,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,505,600.00	5,994,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,124,000.00	23,978,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,498,400.00	25,218,400.00
210301	Гэрэл, цахилгаан	5,498,400.00	5,498,400.00
210302	Түлш, халаалт	18,000,000.00	19,720,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	81,800,250.00	80,967,300.00
210401	Бичиг хэрэг	3,328,000.00	1,823,000.00
210402	Тээвэр, шатахуун	64,179,670.00	69,349,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,593,780.00	2,451,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,649,700.00	326,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,049,100.00	7,016,300.00
2105	Нормативт зардал	133,065,089.00	143,107,481.82
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,919,089.00	104,614,081.82
210502	Хоол, хүнс	25,778,000.00	33,713,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,368,000.00	4,780,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,525,700.00	15,144,900.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,089,000.00	529,100.00
210604	Урсгал засвар	19,436,700.00	14,615,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,520,000.00	3,164,000.00
210702	Дотоод албан томилолт	2,520,000.00	3,164,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,626,226.00	2,573,791.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	439,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,000.00	161,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	810,500.00	1,674,090.00
210807	Газрын төлбөр	299,276.00	299,276.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	300,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,995,800.00	74,432,845.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,995,800.00	74,432,845.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(67,011,294.63)	(56,347,336.37)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,660,930.00	8,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,660,930.00	8,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	37,660,930.00	8,200,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,660,930.00	8,200,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(37,660,930.00)	(8,200,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(104,672,224.63)	(64,547,336.37)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	169,219,561.00	64,547,336.37
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	64,547,336.37	00.00

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/Төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	120,456,759.50	1,555,256,378.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,050,099.00	2,050,099.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	699,896,598.00	734,903,021.48	122,506,858.50	1,557,306,477.98
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	(2,050,099.00)	00.00	(2,050,099.00)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнийбууралт	4,994,000.00	00.00	00.00	4,994,000.00
Тайлант үеийн үр дүн	-	00.00	246,762,009.92	246,762,009.92
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	704,890,598.00	732,852,922.48	369,268,868.42	1,807,012,388.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	704,890,598.00	732,852,922.48	369,268,868.42	1,807,012,388.90
Тайлант үеийн үр дүн	-	-	900,068,884.11	900,068,884.11
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	704,890,598.00	732,852,922.48	1,269,337,752.53	2,707,081,273.01

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,703,791,745.47	1,635,436,268.47	68,355,477.00	96.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,703,791,745.47	1,635,436,268.47	68,355,477.00	96.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,703,791,745.47	1,635,436,268.47	68,355,477.00	96.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,157,629,600.00	1,137,325,276.63	20,304,323.37	98.2
210101	Үндсэн цалин	698,217,000.00	683,346,669.63	14,870,330.37	97.9
210102	Нэмэгдэл	358,248,600.00	357,201,607.00	1,046,993.00	99.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,390,000.00	23,003,000.00	4,387,000.00	84.0
210104	Урамшуулал	73,774,000.00	73,774,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,987,200.00	145,302,273.55	2,684,926.45	98.2
210201	Тэтгэврийн даатгал	100,031,300.00	97,346,373.55	2,684,926.45	97.3
210202	Тэтгэмжийн даатгал	11,988,900.00	11,988,900.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,994,500.00	5,994,500.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,994,500.00	5,994,500.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	23,978,000.00	23,978,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,218,400.00	25,218,400.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	5,498,400.00	5,498,400.00	-	100.0
210302	Түлш, халаалт	19,720,000.00	19,720,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	95,774,000.00	80,967,300.00	14,806,700.00	84.5
210401	Бичиг хэрэг	2,867,400.00	1,823,000.00	1,044,400.00	63.6
210402	Тээвэр, шатахуун	78,932,000.00	69,349,400.00	9,582,600.00	87.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,451,700.00	2,451,700.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,559,400.00	326,900.00	1,232,500.00	21.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,963,500.00	7,016,300.00	2,947,200.00	70.4
2105	Нормативт зардал	154,149,900.00	143,107,481.82	11,042,418.18	92.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	110,136,700.00	104,614,081.82	5,522,618.18	95.0
210502	Хоол, хүнс	37,513,200.00	33,713,400.00	3,799,800.00	89.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,500,000.00	4,780,000.00	1,720,000.00	73.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,878,800.00	23,344,900.00	13,533,900.00	63.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,572,100.00	8,729,100.00	5,843,000.00	59.9
210602	Тавилга	1,500,000.00	-	1,500,000.00	-
210604	Урсгал засвар	20,806,700.00	14,615,800.00	6,190,900.00	70.2
2107	Томилолт, зочны зардал	4,800,000.00	3,164,000.00	1,636,000.00	65.9
210702	Дотоод албан томилолт	4,800,000.00	3,164,000.00	1,636,000.00	65.9
2108	Бусдаар	3,352,300.00	2,573,791.00	778,509.00	76.8

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж				
210803	Даатгалын үйлчилгээ	439,500.00	439,425.00	75.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,000.00	161,000.00	1,000.00	99.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	-	132,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,756,900.00	1,674,090.00	82,810.00	95.3
210807	Газрын төлбөр	299,300.00	299,276.00	24.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	562,600.00	-	562,600.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,001,545.47	74,432,845.47	3,568,700.00	95.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,001,545.47	74,432,845.47	3,568,700.00	95.4
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,703,791,745.47	1,635,436,268.47	68,355,477.00	96.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,824,700.00	28,824,700.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	28,824,700.00	28,824,700.00	-	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,542,661,200.00	1,474,305,686.63	68,355,513.37	95.6
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,542,661,200.00	1,474,305,686.63	68,355,513.37	95.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	132,305,845.47	132,305,881.84	(36.37)	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,758,545.47	67,758,545.47	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	64,547,300.00	64,547,336.37	(36.37)	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	46	47	(1)	102.2
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	38	35	3	92.1
620003	Үйлчлэх ажилтан	7	11	(4)	157.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа нь

Ногооннуур сумын ЭМТ-ийн эрхэм зорилго нь Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөөс анхан шатны болон үндсэн мэргэшлийн нэн шаардлагатай зарим тусламж үйлчилгээг иргэнд тэгш хүртээмжтэй, тасралтгүй, чанартай, цогц байдлаар үзүүлэхэд оршино.

ЗОРИЛТ: Байгууллагын бүтэц орон тоог оновчтой зохион байгуулж, хүний нөөцийг хөгжүүлэх, орчин үеийн тоног төхөөрөмжөөр ханган, материаллаг баазыг бэхжүүлэх, эм эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцоход цахим сүлжээг өргөнөөр ашиглах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүх нийтийг хамруулан, хэнийг ч орхигдуулахгүй байх

Ногооннуур сумын ЭМТ нь:

а. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

б. Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/
- Засгийн газрын 2024.02.28-ний өдрийн Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84 дүгээр тогтоол,
- Засгийн газрын 2024.03.27-ний өдрийн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 05 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 06 дугаар тогтоол.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд мэргэжлийн байгууллагуудаас ямар нэгэн хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 900,068.9 мянган төгрөгөөр буюу 49.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	64,547.3	-	(64,547.3)
Авлага	24,802.4	145,920.5	121,118.1
Бараа материал	175,794.0	194,591.5	18,797.5
Үндсэн хөрөнгө	1,541,868.6	2,366,569.3	824,700.7
Нийт хөрөнгө	1,807,012.3	2,707,081.3	900,069.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,807,012.3	2,707,081.3	900,069.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,807,012.3	2,707,081.3	900,069.0

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 64,547.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэлгүй байна. Тайлант хугацаанд нийт 1,570,888.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,635,436.3 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 145,920.5 мянган төгрөг болж 121,118.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу авсан санхүүжилттэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 194,591.5 мянган төгрөг болж 18,797.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 12,422.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, урсгал санхүүжилтээс 254,196.6 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 247,821.3 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,366,569.3 мянган төгрөг болж, 824,700.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 956,872.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 8,200.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 140,372.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 2,707,081.3 мянган төгрөг болж 900,069.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлан оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,572,600.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 29,526.5 мянга, нийт зарлагыг 1,602,126.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 4,589.3 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 523.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20,037.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь тариф нэмэгдүүлэх санал өгсөнтэй холбоотой, хангамж, бараа материалын зардлыг 6,287.0 мянга, норматив зардлыг 664.9 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 2,863.4 мянга, томилолт, зочны зардлыг 1,496.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 157.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,723.1 мянга, бусад урсгал шилжүүлгийг мянган төгрөгөөр бууруулж, 1,570,888.9 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн хэмнэлт гаргахыг зорьсонтой холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 31,238.0 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71602 хөтөлбөрийн 80302 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,064,463.1 мянга, 81603 арга хэмжээг санхүүжүүлэхээр 477,601.1 төгрөгийг улсын төсвөөс, 28,824.7 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжилтээс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,542,064.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 28,824.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, оны эхний үлдэгдлээс 64,547.3 мянган төгрөгийг зарцуулж, нийт 1,635,436.4 мянган төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,635,436.4 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг бүрэн зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,674,967.0	1,606,611.6	68,355.4	95.9
1.1	80302 Нэг иргэнд ногдох норматив	1,065,060.1	1,041,659.6	23,400.5	97.8%
1.2	81603 үндсэн мэргэжлийн	542,148.4	497,193.5	44,954.9	91.7%

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	тусламж үйлчилгээ				
1.3	83601 Нэмэлт - Олон улсын байгууллагаас олгосон	67,758.5	67,758.5	-	100.0%
2	71601 Нийгмийн эрүүл мэнд				
2.1	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	28,824.7	28,824.7	-	100.0%
	Нийт	1,703,791.7	1,635,436.3	68,355.4	96.0%

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 96.0 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Бараа материал

2024 оны төсвийн жилд эм, эмнэлгийн хэрэгслийн эхний үлдэгдэл 116,594,7 мянган төгрөг байсан ба тайлант онд нийт 104,614.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн төсвийн хөрөнгөөр худалдаж авсан. Мөн аймгийн ЭМГ-аас 6,562.9 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл ирснийг үнэ төлбөргүй хүлээж авсан ба тайланд онд 94,124.6 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг зарцуулж, 133,647.3 төгрөгийн үлдэгдэлтэй үлдсэн.

Бичиг хэргийн материалын оны эхний үлдэгдэл 2,301.4 мянган төгрөг байсан ба төсвийн хөрөнгөөр 1,823.0 төгрөгийн бичиг хэргийг худалдан авч 1,624.6 мянган төгрөгийн бичиг хэргийг зарцуулсан. Мөн бусад хангамжийн материалын эхний үлдэгдэл 47,875.5 мянган төгрөг байсан ба төсвийн хөрөнгөөр 17,035.7 мянга, Аймгийн ЭМГ-аас 5,859.2 мянган төгрөгийн аж ахуй материалыг хүлээн авч 18,938.1 мянган төгрөгийн материалыг зарцуулж, тайлагнасан болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор цалингийн нэмэгдэл урамшуулал, үндсэн хөрөнгийн бүртгэл болон баримт баталгаажуулалт, Төрийн хэмнэлтийн хуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Лайт энд Дилайт Аудит” ХХК-ийн аудитор Л.Мөнхцэцэг гүйцэтгэж, аудитын менежер Ц.Төмөрсүх, компанийн захирал М.Нурболат нар анхан шатны чанарын хяналтыг, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,242,737.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,641.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 191 мэдээллээс 132 мэдээллийг хугацаанд нь байршуулсан ба Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш 51 удаагийн 1,574,798.6 мянган төгрөгийн орлого/зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон, 7 удаагийн 322,329.1 мянган төгрөгийн орлого/зарлагын гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хувь 70.1 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээллийг нөхөж байршуулж цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,564.1 мянган төгрөгийн албан шаардлага, 76,347.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн нь 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	1,564.1	1	1,564.1	100.0
Зөвлөмж	2	76,347.3	2	76,347.3	100.0
Нийт дүн	1	77,911.4	1	77,911.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн.

Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа¹ илрээгүй болно.

Аудитаар нийт 393,180.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс цаашид давтан гаргахгүй ажиллах 4 зөвлөмж өгч ажилласан.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд: нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны төлбөрийн үлдэгдэл 151.2 мянган төгрөгийн үлдэгдлийг аккруэл сууриар бүртгээгүй, өглөг үүсгээгүй байна.

Цахим төлбөрийн нэхэмжлэхгүй 1,488.0 мянган төгрөгийн үнэ бүхий сэлбэгийн төлбөр төлсөн.

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨБАҮХАТ)-ийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5 "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 45 дугаар зүйлийн 45.3. "Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна", Засгийн газрын 2025 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Цахим төлбөрийн нэхэмжлэх/төлбөрийн баримтын талаар

2.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд цахим төлбөрийн нэхэмжлэхгүй 1,488.0 мянган төгрөгийн үнэ бүхий сэлбэгийн төлбөр төлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1. "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн үр чадвар, ёс зүйтэй байх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бөгөөд дараах бүрэн эрх, үүрэгтэй байна: 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэснийг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагаас ирүүлсэн цахим нэхэмжлэхийн дагуу төлбөр тооцоо гүйцэтгэх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг мөрдөөгүй байна.

3.1. Илрүүлэлт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны төлбөрийн үлдэгдэл 151.2 мянган төгрөгийн үлдэгдлийг аккруэл сууриар бүртгээгүй, өглөг үүсгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэснийг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагаас худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээний нэхэмжлэхийг төлбөр төлсөн эсэхээс үл хамаарч хүлээн зөвшөөрөх шалгуур хангасан үед бүртгэлд тусгаж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Албан шаардлага				Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Цахим төлбөрийн нэхэмжлэхгүй 1,488.0 мянган төгрөгийн үнэ бүхий сэлбэгийн төлбөр төлсөн.	1	1,488.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны төлбөрийн үлдэгдэл 151.2 мянган төгрөгийн үлдэгдлийг акрузал сууриар бүртгээгүй, өглөг үүсгээгүй байна.	1	151.2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН	3	1,639.2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Албан шаардлага				Зөвлөмж			
	Тоо		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил														
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш 51 удаагийн 1,574,798.6 мянган төгрөгийн орлого/зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон, 7 удаагийн 322,329.1 мянган төгрөгийн орлого/зарлагын гүйлгээг байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хувь ... хувьтай байна.	1	322,329.1	-	-	-	-	-	-	-	-	-	1	322,329.1	
ДҮН	1	322,329.1	-	-	-	-	-	-	-	-	-	1	322,329.1	